

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. Аудитын илрүүлэлт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Д.ДОРЖГОТОВ
ТАНАА

2023.02.13 № УВА-2023/39/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд эрт илрүүлгийн үзлэгтэй холбоотой Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 1,300.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, 300.0 сая төгрөгийн засвар хийж Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,687,966,486.39	4,159,899,082.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,129,172.73	1,048,493,764.86
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	6,129,172.73	1,048,493,764.86
31210	Төгрөг	6,129,172.73	1,048,493,764.86
31211	Төрийн сангийн харилцах	6,129,172.73	1,048,493,764.86
33	АВЛАГА	2,667,589,622.00	2,107,944,164.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	5,843,558.71
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,666,104,922.00	2,100,615,905.74
33500	Бусад авлага	1,484,700.00	1,484,700.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,484,700.00	1,484,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,014,247,691.66	1,003,461,153.49
35100	Түүхий эд материал	735,313,524.52	638,191,073.03
35130	Эм боох материал	735,313,524.52	638,191,073.03
35400	Хангамжийн материал	278,934,167.14	365,270,080.46
35410	Бичиг хэргийн материал	5,524,670.00	8,469,500.00
35420	Аж ахуйн материал	11,861,366.29	8,928,616.29
35430	Сэлбэг хэрэгсэл	25,593,322.00	24,607,891.00
35440	Түлш, шатах тослох материал	51,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	3,559,950.00	5,929,450.00
35460	Хүнсний материал	2,188,380.06	25,887,321.76
35470	Бусад хангамжийн материал	230,155,478.79	291,447,301.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,113,058,039.36	16,149,504,603.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,113,058,039.36	16,149,504,603.28
39200	Биет хөрөнгө	13,477,859,289.36	15,514,380,853.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,894,937,850.70	8,986,020,192.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-395,765,350.60	-569,908,475.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	772,644,432.33	1,044,912,712.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	-535,242,275.39	-566,832,277.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,875,987,631.09	13,522,155,458.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,482,364,858.55	-7,417,103,952.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	500,734,658.41	707,491,229.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-305,240,883.30	-336,321,801.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	233,859,830.94	255,886,629.68
39215	Хуримтлагдсан элэгдэл	-82,355,946.27	-112,583,062.95
39217	Ном	664,200.00	664,200.00
39300	Биет бус хөрөнгө	635,198,750.00	635,123,750.00
39301	Программ хангамж	2,400,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,281,250.00	-2,356,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	635,080,000.00	635,080,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,801,024,525.75	20,309,403,686.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	836,629,072.65	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	836,629,072.65	0.00
41300	Өглөг	836,629,072.65	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,508,621.05	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	812,924,651.60	0.00
41360	Бусад өглөг	19,195,800.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,100,800.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	95,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,964,395,453.10	20,309,403,686.08

51	Засгийн газрын хувь оролцоо	16,964,395,453.10	20,309,403,686.08
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,952,435,948.94	4,952,435,948.94
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	4,952,435,948.94	4,952,435,948.94
51200	Хуримтлагдсан үр дүн	6,307,277,217.01	9,652,909,528.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,684,686,984.45	6,307,901,295.82
51220	Тайлант үеийн үр дүн	4,622,590,232.56	3,345,008,232.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,704,682,287.15	5,704,058,208.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,801,024,525.75	20,309,403,686.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	18,151,609,848.20	18,009,356,519.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,579,751,821.20	3,954,435,528.48
120	Нийтлэг татварын бус орлого	4,579,751,821.20	3,954,435,528.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,048,950.00	530,406,461.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,048,950.00	408,940,309.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	121,466,152.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,516,280,415.28	3,071,420,526.55
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	872,422,455.92	352,608,540.29
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,571,858,027.00	14,054,920,991.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	930,547,252.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	479,528,202.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,402,050.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	362,617,000.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	785,000,000.00	0.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	465,000,000.00	0.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	320,000,000.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,856,310,775.00	14,054,920,991.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,856,310,775.00	14,054,920,991.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,525,591,487.12	14,656,983,245.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,525,591,487.12	14,656,983,245.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,033,774,657.12	14,628,037,745.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,235,681,732.35	7,560,227,535.29
210101	Үндсэн цалин	5,503,096,884.35	4,627,091,541.70
210102	Нэмэгдэл	572,310,130.00	2,051,368,455.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,250,604.00	209,411,749.59
210104	Урамшуулал	100,024,114.00	672,355,789.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	783,843,505.65	952,058,447.61

210201	Тэтгэврийн даатгал	546,251,128.46	647,399,738.63
210202	Тэтгэмжийн даатгал	60,407,748.23	76,164,674.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	45,297,236.56	60,931,740.95
210204	Ажилгүйдлийн даатгал	11,071,896.21	15,232,934.56
210205	Эрүүл мэндийн даатгал	120,815,496.19	152,329,358.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	845,981,067.83	989,157,057.92
210301	Гэрэл, цахилгаан	78,824,575.83	110,897,902.92
210302	Түлш, халаалт	527,775,575.00	672,112,782.00
210303	Цэвэр, бохир ус	239,380,917.00	206,146,373.00
2104	Хангамж, бараа материалын зардал	179,458,095.62	267,838,305.77
210401	Бичиг хэрэг	15,606,265.00	26,536,565.00
210402	Тээвэр, шатахуун	74,762,950.10	142,972,752.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,380,729.79	7,875,760.00
210404	Ном, хэвлэл	33,300.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,245,282.00	4,895,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,872,775.00	64,985,355.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	17,556,793.73	20,572,423.27
2105	Нормативт зардал	3,784,320,898.50	3,243,730,773.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,524,366,614.30	3,010,529,685.67
210502	Хоол, хүнс	258,694,284.20	233,201,088.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,260,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,060,414.20	110,624,566.67
210601	Багаж, техник, хэрэгсэл	900,000.00	0.00
210604	Урсгал засвар	49,160,414.20	110,624,566.67
2107	Томилолт, зочны зардал	12,012,000.00	31,464,800.00
210702	Дотоод албан томилолт	12,012,000.00	31,464,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,124,932.00	148,923,501.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,930,000.00	105,106,506.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,262.00	466,690.64
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,800.00	275,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,260,100.00	15,078,000.00
210807	Газрын төлбөр	6,350,800.00	6,350,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,649,970.00	19,006,505.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,089,292,010.97	1,324,012,756.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	29,317,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,089,112,010.97	1,294,695,556.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,816,830.00	28,945,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	491,816,830.00	28,945,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	469,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,816,830.00	28,945,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,626,018,361.08	3,352,373,274.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,428,128.52	7,365,041.02
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,428,128.52	7,365,041.02
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,622,590,232.56	3,345,008,232.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,096,802,055.00	15,150,816,468.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,048,950.00	548,459,461.64
120	Нийтлэг татварын бус орлого	191,048,950.00	548,459,461.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,048,950.00	548,459,461.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,048,950.00	408,940,309.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	139,519,152.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,905,753,105.00	14,602,357,007.26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	930,547,252.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	479,528,202.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,402,050.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	362,617,000.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	785,000,000.00	0.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	465,000,000.00	0.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	320,000,000.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,190,205,853.00	14,602,357,007.26
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,190,205,853.00	14,602,357,007.26
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,912,195,949.27	13,841,365,241.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,912,195,949.27	13,841,365,241.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,420,827,849.27	13,807,694,741.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,155,214,113.95	7,605,608,112.61
210101	Үндсэн цалин	3,251,555,885.00	4,672,472,119.02
210102	Нэмэгдэл	2,289,618,339.18	2,051,368,455.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	206,505,465.00	209,411,749.59
210104	Урамшуулал	407,534,424.77	672,355,789.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	860,981,353.00	915,851,200.05
210201	Тэтгэврийн даатгал	631,250,778.01	623,654,651.90
210202	Тэтгэмжийн даатгал	58,301,248.07	73,371,013.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,547,338.26	58,575,910.96
210204	Ажилгүйдлийн даатгал	11,353,044.60	14,539,517.41
210205	Эрүүл мэндийн даатгал	113,528,944.06	145,710,105.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	610,925,225.83	1,224,871,522.92
210301	Гэрэл, цахилгаан	78,824,575.83	85,802,876.92
210302	Түлш, халаалт	310,600,750.00	914,784,633.00
210303	Цэвэр, бохир ус	221,499,900.00	224,284,013.00
2104	Хангамж, бараа материалын зардал	155,644,074.29	282,505,744.30
210401	Бичиг хэрэг	14,434,000.00	22,022,500.00
210402	Тээвэр, шатахуун	65,660,635.50	154,895,179.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,220,729.79	9,035,760.00

210404	Ном, хэвлэл	33,300.00	660,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,394,200.00	12,004,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,901,209.00	83,888,305.00
2105	Нормативт зардал	2,545,125,634.20	3,425,009,133.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,257,808,284.20	3,140,442,303.25
210502	Хоол, хүнс	277,722,550.00	256,246,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,594,800.00	28,320,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,448,786.00	118,646,382.00
210604	Урсгал засвар	29,448,786.00	118,646,382.00
2107	Томилолт, зочны зардал	12,012,000.00	31,464,800.00
210702	Дотоод албан томилолт	12,012,000.00	31,464,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,296,662.00	158,243,146.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,750,000.00	107,315,356.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,262.00	466,690.64
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	275,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,108,400.00	16,094,500.00
210807	Газрын төлбөр	6,350,800.00	6,350,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,191,200.00	25,100,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,000.00	45,494,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,247,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	30,247,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,368,100.00	33,670,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	491,368,100.00	33,670,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	469,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,368,100.00	33,670,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	184,606,105.73	1,309,451,227.13
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	178,476,933.00	267,086,635.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	178,476,933.00	267,086,635.00
2200	Дотоод эх үүсвэрээр	178,476,933.00	267,086,635.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	178,476,933.00	267,086,635.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-178,476,933.00	-267,086,635.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,129,172.73	1,042,364,592.13
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,129,172.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,129,172.73	1,048,493,764.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,682,287.15	1,684,686,984.45	12,341,805,220.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,682,287.15	1,684,686,984.45	12,341,805,220.54
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,622,590,232.56	4,622,590,232.56
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,682,287.15	6,307,277,217.01	16,964,395,453.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,682,287.15	6,307,277,217.01	16,964,395,453.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	624,078.81	624,078.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,682,287.15	6,307,901,295.82	16,965,019,531.91
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-624,078.81	0.00	-624,078.81
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,345,008,232.98	3,345,008,232.98
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,952,435,948.94	5,704,058,208.34	9,652,909,528.80	20,309,403,686.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,048,315,500.00	14,064,813,924.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,048,315,500.00	14,064,813,924.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,021,015,500.00	14,037,563,924.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,414,581,000.00	7,605,608,112.61
210101	Үндсэн цалин	3,904,510,100.00	4,672,472,119.02
210102	Нэмэгдэл	3,034,913,100.00	2,051,368,455.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	304,920,000.00	209,411,749.59
210104	Урамшуулал	1,170,237,800.00	672,355,789.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,051,822,600.00	915,851,200.05

210201	Тэтгэврийн даатгал	715,239,400.00	623,654,651.90
210202	Тэтгэмжийн даатгал	84,145,800.00	73,371,013.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	67,316,600.00	58,575,910.96
210204	Ажилгүйдлийн даатгал	16,829,200.00	14,539,517.41
210205	Эрүүл мэндийн даатгал	168,291,600.00	145,710,105.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,233,655,100.00	1,224,871,522.92
210301	Гэрэл, цахилгаан	87,053,700.00	85,802,876.92
210302	Түлш, халаалт	914,403,700.00	914,784,633.00
210303	Цэвэр, бохир ус	232,197,700.00	224,284,013.00
2104	Хангамж, бараа материалын зардал	289,908,400.00	282,505,744.30
210401	Бичиг хэрэг	21,588,000.00	22,022,500.00
210402	Тээвэр, шатахуун	169,141,500.00	154,895,179.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,042,300.00	9,035,760.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	660,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,394,200.00	12,004,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	74,742,400.00	83,888,305.00
2105	Нормативт зардал	3,453,293,900.00	3,425,009,133.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,168,197,100.00	3,140,442,303.25
210502	Хоол, хүнс	256,707,600.00	256,246,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,389,200.00	28,320,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	378,005,100.00	366,463,065.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	262,280,900.00	253,459,285.00
210602	Тавилга	2,635,000.00	2,339,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	974,400.00	0.00
210604	Урсгал засвар	112,114,800.00	110,664,430.00
2107	Томилолт, зочны зардал	33,445,500.00	31,464,800.00
210702	Дотоод албан томилолт	33,445,500.00	31,464,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,303,900.00	155,543,146.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,678,900.00	104,615,356.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	871,200.00	466,690.64
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	500,000.00	275,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,141,400.00	16,094,500.00
210807	Газрын төлбөр	6,350,800.00	6,350,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,121,600.00	25,100,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	30,247,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	30,247,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,300,000.00	27,250,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,300,000.00	27,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,300,000.00	27,250,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,048,315,500.00	15,107,178,516.90
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,740,147,300.00	14,602,357,007.26
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,740,147,300.00	14,602,357,007.26
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	308,168,200.00	504,821,509.64

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	213,168,200.00	408,940,309.64
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,000,000.00	95,881,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,129,172.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,048,493,764.86

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нэгдсэн эмнэлэг нь иргэдэд эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг ба “Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн лавлагаа тусламж үйлчилгээг ээлтэй, чанартай, тасралтгүй тэгш хүртээмжтэй үзүүлж өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино” гэсэн зорилгын дор 2023 онд доорх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Ёс зүй харилцаа хандлагыг эрхэмлэж ёс зүйн зөрчилгүй хамт олон болох.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын хяналтыг сайжруулж нэхэмжлэлийн хасагдалгүй ажиллах.
- Байгууллагын дотоод цахим сүлжээг шинэчлэх, дамжих чадварыг сайжруулах, кибер халдлагаас хамгаалах чиглэлээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулан батлуулж үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Ажиллагсад үйлчлүүлэгчдийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж засвар тохижилт хийх. Тухайлбал: Хавдар хөнгөвчлөх тасаг, гал тогоо хоол үйлдвэрлэлийн хэсэг, угаалга ариутгалын барилга, орох хаалга, хүнсний агуулах гэх мэт
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бариулах эмнэлгийн өргөтгөлийн газар чөлөөлөх дэд бүтцийг татах болон барилгын ажлыг эхлүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187,174.3 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,129.2	1,048,493.8	1,042,364.6
Авлага	2,667,589.6	2,107,944.2	-559,645.4
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	1,014,247.7	1,003,461.1	-10,786.6
Үндсэн хөрөнгө	14,113,058.0	16,149,504.6	2,036,446.6
Нийт хөрөнгө	17,801,024.5	20,309,403.7	2,508,379.2
Өр төлбөр	836,629.1	0,00	-836 629.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,964,395.4	20,309,403.7	3,345,008.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17 801 024. 5	20,309,403.7	2,508,379.2

Бараа материалын дансны үлдэгдэл 1,003,461.1 мянган төгрөг болж 10,786.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны бараа материалын үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,149,504.6 мянган төгрөг болж 2,036,446.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийг дэмжих төвийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 244,337.1 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 2,973,551.4 мянга, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газраас 6,786.8 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан бөгөөд нийт 3,224,675.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс 100,205.3 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 20,309,403.7 мянган төгрөг болж 3,345,008.2 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яам, орон нутгаас хөрөнгө оруулалт хийгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,982,316.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 14,982,316.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,001.0 мянган төгрөгөөр бууруулж 14,953,315.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь байгууллагаас төлөх шимтгэлийг бууруулж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,953,315.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 213,168.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 14,740,147.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 408,940.3 мянга, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн орлого 14,602,357.0 мянга, туслах үйл ажиллагааны орлого 95,881.2 мянга, нийт 15,107,178.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 14,064,813.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,064,813.9 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь 1,042,364.6 төгрөгийг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 71602 – Үндсэн үйл ажиллагаа 80801	14,926,015.5	13,943,813.9	983,451.6	93.4%
2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 71602 – Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 80802	27,300.0	27,250.0	50.0	99.8%
3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 71602 – Нэмэлт-Дээд шатнаас хуваарилсан 83603	95,000.0	93,750.0	1,250.0	98.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 10,515.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 18,053.0 мянга үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,069.9 мянга, нийт 43 637.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тавилга эд хогшил худалдан авах зардалд 4,500.0 мянга, урсгал засварын зардалд 14,769.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,700.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 15,247.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,420.5 мянга, нийт 43,637.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 58.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,657.0 сая төгрөгийн 0.5 хувь буюу 73.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 58.6 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Нэгдсэн эмнэлгийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 129, хугацаа хоцроож байршуулсан 20, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нэгдсэн эмнэлэг нь 3,361,145.1 мянган төгрөгийн 20 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,986.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 11,486.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 22,500.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

Цалин, нэмэгдэлтэй холбоотой дараах зөрчлүүдийг нэгтгэн 1 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Нэгдсэн эмнэлгийн даргаар ажиллаж байсан О.Одбаяр, дарга Д.Доржготов нарт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/351 дүгээр тушаалаар ирүүлсэн чиглэлийг үндэслэн 3,397.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.
2. Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны Б/47 дугаар тушаалаар нэр бүхий 21 албан хаагчид хууль тогтоомжид заагдаагүй хариуцлагын нэмэгдэл 6,949.4 мянган төгрөгийг байгууллагын дотоод журамд тусгаж олгосон.
3. Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны Б/151 дүгээр тушаалаар сүлжээний инженер Ц.Батмөнх /нууцтай танилцах эрхтэй/-д нууц хамгаалах ажилтны нэмэгдэл 1,139.8 мянган төгрөг олгосон байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэгдсэн эмнэлэг нь 3,361,145.1 мянган төгрөгийн 20 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бишрэлт анд, Оргил нуурын эх компаниудтай байгуулсан гэрээнд тохируулга хийхээр тусгаагүй ч суурь үнэ огцом өссөн шалтгаанаар тохируулга хийсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно” гэж заасныг мөрдөж ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй Дрийм еспортс ХХК, Цалгар анд ХХК-удаас эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Эм хангамжийн

байгууллагын үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно”, 11.1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах”, 11.1.3 дахь заалтад “Эм, эмнэлгийн хэрэгслийг эм хангамжийн байгууллагаас бусад эх үүсвэрээс авах” гэж заасныг мөрдөж ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Хавсран ажилласны нэмэгдэл олгох тушаалуудад ямар албан тушаалтны ажлыг хавсруулах талаар тодорхой тусгаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид хавсран ажилласны нэмэгдэл олгох тушаалд ямар албан тушаалтны ажлыг хавсруулах талаар тодорхой тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хууль тогтоомж зөрчиж нэмэгдэл, урамшуулал олгосон.	1	11,486.2			1	11,486.2							
Дүн	1	11,486.2			1	11,486.2							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн.	1	3,361,145.1					1	3,361,145.1
Дүн	1	3,361,145.1					1	3,361,145.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Гэрээнд тусгахгүйгээр үнийн тохируулга хийсэн.	1						1	
Тусгай зөвшөөрөлгүй ААН-ээс эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан.	1	22,500.0					1	22,500.0
Хавсран ажиллах тушаалын заалт тодорхойгүй.	1						1	
Дүн	3	22,500.0					3	22,500.0
Нийт дүн	4	3,383,645.1					4	3,383,645.1

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 13-ны өдөр